

**Монголчуудын хэл, түүх, соёлд холбогдох
араб, перс бичгийн дурсгалын тойм**

Аззаяа Б.
/МУИС/

Дундад эртний үед холбогдох араб, перс хэл бичгээрх сурвалжуудын дотор Монголчуудын хэл, түүх соёлд холбогдох чухаг бүтээлүүд цөөнгүй буй билээ.

Харин тэдгээр сурвалжийг монгол хэлнээ орчуулж, судалсан нь чамлалтай цөөн, тэгээд ч эх бичиг, уг сурвалжаас бус дам оруулга, бүтээлээс эх хэрэглэгдэхүүн болгон ашигласаар иржээ. Тиймээс монголчуудын хэл, түүх, соёлд холбогдох араб, перс сурвалжийг орчуулж, судлахын чухлыг өгүүлэхийн ялдамд зарим сурвалжийн талаар цухас танилцуулахыг зорилоо.

Монголын түүхэнд холбогдох араб үсгээрх дурсгал буюу түүхэн сурвалжуудыг:

1. Араб, перс хэл, бичгээр
2. Араб үсэг, монгол хэлээр
3. Араб үсэг, түрэг хэлээр уламжлагдан ирсэн хэмээн ангилан үзэж болох юм.

а. Араб, перс хэл, бичгээр уламжлагдан ирсэн томоохон дурсгалд:

- Нур-ад-Диний бичиг,
- Ала-ад-Дин Ата Мэлик Жүвэйний “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”
- Рашид-ад-Диний “Судрын чуулган” гэх гурван дурсгалыг дурдаж болох юм.

Нур-ад-Диний бичиг.

Нур-ад-Диний бичгийн:

- Искилибийн гар бичмэл /618 мөр араб бичиг/
- Кыршехирийн 1-р гар бичмэл /425 мөр араб, 61+6 мөр монгол эх бичиг/
- Кыршехирийн 2-р гар бичмэл /175 мөр араб, 9 мөр монгол эх бичиг/

гэсэн гурван хувилбар эх олджээ.

Уг дурсгалд Кыршехирийн ноён Баха-ад-Дин Жажагийн хүү Нур-ад-Дин Жэбрайл Жажа 1272 онд өөрийнх нь харьяат Кыршехир, Искилиб, Кочхисар,

Султанюуги хотууд болон тэдгээрийн эргэн тойрон, мөн Анкарагийн нэгэн хэсэг, Коня, Аксарай мужуудад байх өөрийн эдлэн газар, эд хөрөнгөө үр ач нартаа, түүнчлэн Кыршехир, Искилиб, Талымэгини, Султанюуги, Каясэри зэрэг хотуудын лалын сүм хийд, дацан, албан хэргийн газар хийгээд бусад байгууллагад сан болгон үлдээсэн¹ талаар тэмдэглэгдсэн байна.

Нур-ад-Дин гэдэг нь араб хэлний نور الدين “Шашны гэрэл” гэсэн утгатай үг юм.

Нур-ад-Динийг “... ноён, их цэргийн жанжин, эрдэм билигт, шудрага сайн сэтгэлт, ялагч, итгэл үнэмшлийн төлөө тэмцэгч, үнэн сүсэгт, туслан дэмжигч, сайн үйлс, туслалцаа, дэмжлэгт өрсөлдөгч, шашин номыг сайжруулахын төлөө тэмцэгч, буян үйлдэгч, амьдралд дуртай, өглөгч, хүнлэг энэрэнгүй сэтгэлт, өрөвч зөөлөн, анхаарал халамжит, хүндэт, суут ухаант, цэвэр ариун, сэхээтэн, төр болоод шашны гэрэл гэгээ, лалын шашин болон лалын шашинтнуудад хүндлэгдсэн, хаад ноёдод туслагч, агуу их цэрэг асан جاجا بها الدين Баха-ад-Дин Жажагийн хүү Жэбрайл...” хэмээсэн байдаг². Ер Нур-ад-Дин нь төр шашны томоохон зүтгэлтэн, ялангуяа шашныг дэлгэрүүлэх үйлст ихээхэн үүрэг гүйцэтгэж байсан ард түмний хайр хүндэтгэлийг хүлээсэн хүн байжээ.

Үүнийг Эскишехир, Кыршехир зэрэг хотуудын шашны сүмийн хана, хаалганы ابن نيل جبر ته مغفر الله حمة الى المحتاج العبد خاха гэх мэтийн бичээсүүдээс тодорхой харж болно.

Эдгээр сангийн бичгийг Түрэгийн эрдэмтэн түрэгч-монголч профессор, доктор Ахмет Тамир анх удаа тал бүрээс нь нарийвчлан судалж, гурван араб эх болон тус бүрийнх нь орчуулга мөн гурван монгол эхийн галиг, турк орчуулга, хэлний тайлбар, түүхийн шинжилгээ, үгийн хэлхээ, 12 гэрэл зургийн хамт “Кыршехирийн ноён Жажагийн хүү Нур-ад-Диний 1272 оны Араб-монгол хэлээрх сангийн бичиг” нэрээр ном болгон 1959 онд хэвлүүлжээ. Эл ном 1989 онд дахин хэвлэгдсэн байна³.

Мөн Мажарын эрдэмтэн, академич Л.Лигети 1972 онд хэвлүүлсэн сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалын эмхитгэлдээ уг сурвалжийн монгол эхийн галигийг оруулжээ⁴.

Доктор М.Ууганбаяр эл сангийн бичгийн монгол эхүүдийн авиан галиг, хөрвүүлгэ, үгийн хэлхээ, тайлбар сэлтийг үйлдэн эрдэм шинжилгээний өгүүлэл болгон хэвлүүлсэн билээ⁵. Эл судалгаа өмнөх эрдэмтдийн монгол эхийн галиг, орчуулгад гаргасан алдаа мадаг, таашаарлыг залруулж, нарийвчлан судлахад чиглэгдсэн байна.

¹ A. Temir, Kırşehir emiri Caca oğlu nur el-din'in 1272 tarihli Arapça-Moğolca vakfiyesi, Ankara, 1989, s. 3.

² A. Temir, Kırşehir emiri Caca oğlu nur el-din'in 1272 tarihli Arapça-Moğolca vakfiyesi, Ankara, 1989, s. 201.

³ Б.Арьяажав, Нур-ад-Диний бичгийн 1272 оны араб, монгол эхийн судалгаа, -МУИС, МХСС, Түрэг судлалын тэнхимийн гар бичмэлийн фонд, бүртгэлийн дугаар: Т-2005_2/, бакалаврын дипломын ажил, УБ., 2005, т. 5

⁴ L. Ligeti, Monuments préclassiques I. (XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, p. 270-272.

⁵ М.Ууганбаяр, Кыршехирийн ноён Жажагийн хөвгүүн Нур-ад-Диний бичгийн тухай, -МУИС, эрдэм шинжилгээний бичиг, XX боть, XXXдэвтэр, УБ., 2003, т. 244-265

Харин түрэг судлаач Б.Арьяажав араб эхийн эх бичгийн судалгааг хийж, монгол хэлнээ анх орчуулсан ажээ⁶.

Ж.Тарим, С.Үлгэн, Х.Н.Тургалли нарын Нур-ад-Диний намтар, түүхэнд холбогдох судалгаа бий.

Ала-ад-Дин Ата Мэлик Жүвэйний "Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх"

Ираны нэрт түүхч Ала-ад-Дин Ата Мэлик Жүвэйний перс хэлээр туурвисан уг бүтээл нь XII-XIII зууны үеийн Монгол-Туркийн түүхнээ холбогдох үнэ цэнэтэй, чухал сурвалжийн нэг юм. Монголын эзэнт гүрний үед Ала-ад-Дин Ата Мэлик Жүвэйни нь олон жилийн турш төр засгийн хариуцлагатай алба хашиж, Монголчууд болон Исмаилитуудын хоорондын дайнд оролцож байсан бөгөөд тэрбээр бичсэн зүйлийнхээ дийлэнхийг өөрийн нүдээр үзсэн, эсвэл баттай бичгийн болон аман баримтад тулгуурласан тул зохиогдсон цагаасаа эхлэн ихэд алдаршсан байна.

1911 онд Мирза Мухаммад Казниви гурван ботиор хэвлүүлжээ. Хожим нь Иранд хэвлэгдсэн "Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх"-ийн бүх эх нь уг эхийг тулгуур болгосон байдаг.

XIX зууны эхэн үеэс Европын олон хэлээр, бүлэглэн буюу хэсэгчлэн орчуулж эхэлсэн бөгөөд 1958 онд Жон Бойл бүрэн эхээр нь хоёр боть болгон англи хэлээр орчуулан хэвлүүлсэн байна⁷.

Туркийн эрдэмтэн Mürsel Öztürk турк хэлээр орчуулан гурван боть болгон хэвлүүлсэн байна⁸.

Мөн уг сурвалжийн нэгдүгээр ботийг орос хэлнээс эх хэлнээ М.Д.Бадамням орчуулан хэвлүүлжээ⁹.

Рашид-ад-Диний "Судрын чуулган"

Ираны нэрт эрдэмтэн Рашид-ад-Дин Фазлуллах ибн Абу-л-Хейр Али Хамади /رشيد الدين فضل الله/ (1247-1318)-гийн перс хэлээр туурвисан "Жами-ат-таварих /جامع التواريخ/" буюу "Судрын чуулган" нь Монголын түүхнээ холбогдох чухал сурвалжийн нэг юм.

Рашид-ад-Дин Чингисийн отгон хүү Тулуйн хүү Хулагу /1256-1265/ хааны удмын Хасан /1295-1304/ хааны төрийн сайдаар 1298 онд томилогдон ажиллаж байсан бөгөөд уг бүтээлээ 1301-1311 онд бүрэн дуусгажээ.

Уг сурвалжид монгол, түрэг аймгуудын үүсэл гарлаас эхлэн Чингис хааны өвөг дээдэс, анд нөхөр, түшмэд, түүний үйл ажиллагаа болон дараа дараагийн алтан ургийнхны талаар өгүүлсэн байна. Л.А.Хетагуров энэхүү 3 боть зохиолын нэг,

⁶ Б.Арьяажав, Нур-ад-Диний бичгийн 1272 оны араб, монгол эхийн судалгаа, -МУИС, МХСС, Түрэг судлалын тэнхмийн гар бичмэлийн фонд, /бүртгэлийн дугаар: Т-2005_2/, бакалаврын дипломын ажил, УБ., 2005.

⁷ Ala-ad-Din 'Ata-Malik Juvani, The History of the World-Conqueror, translated from the Persian by John Andrew Boyle, Manchester University Press, Vol. I. II. London. 1958.

⁸ Alaaddin A.M.Cüveynî, Tarih-i Cihangüşa, çev. Mürsel Öztürk, Ankara. 1988.

⁹ Ала-ад-Дин Ата-Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх, орч. М.Д.Бадамням, УБ., 2006.

хоёрдугаар ботийг 1952 онд, гуравдугаар ботийг 1946 онд тус тус орос хэлээр орчуулан хэвлүүлжээ. Мөн 1965 онд эхийг нь А.А.Ромаскевича, А.А.Хетагурова, А.А.Али-заде нар эрхлэн Оросын Шинжлэх ухааны академиас хэвлүүлсэн байна¹⁰.

Л.А.Хетагуровын орос орчуулгаас монгол хэлнээ Ц.Сүрэнхорлоо орчуулан мөн гурван боть болгон гаргажээ¹¹.

б. Араб үсэг, монгол хэлээр уламжлан ирсэн дурсгалд:

- Ибн Муханны толь
- Истанбулын толь
- Мукаддимат-ал-Адаб толь
- Лайдений толь
- Хааны толь /6 хэлний/

зэргийг дурдаж болох юм.

Араб үсгийн монгол дурсгал нь араб үсгээрх монголын түүхэнд холбогдох бусад дурсгалуудаас илүү судлагдсан гэж үзэх үндэстэй юм.

Ибн Муханны толь

Оросын нэрт түрэг судлаач П.М.Мелиоранский персийн эрдэмтэн Ибн Муханны XVI зууны эхээр бичсэн перс-монгол зүйл хуваасан толийн нэгэн хувилбарыг судлан хэвлүүлснээр¹² араб үсгээрх монгол дурсгалыг судлах эхлэл тавигдсан гэж болно. Уг толь нь тус бүрдээ 800 гаруй үгтэй гурван өөр хувилбар уламжлагдан ирсэн байна. Н.Поппе Истанбулд хэвлэгдсэн өөр нэгэн хувилбарыг, профессор М. Weiers Ромын Корзини номын санд байсан өөр нэг хувилбарыг олж тус тусын судалгааны бүтээлийг хэвлүүлжээ¹³.

Нэрт монголч Н.Поппе, П.Пеллио нар XIV зууны персийн түүхч Хамдуллаха Казвиний “Зүрхний гэрэл /1339/” гэх номын доторх ан амьтны нэрийн тольд тэмдэглэгдсэн үгсийг судалжээ¹⁴.

Истанбулын толь

“... “Истанбулын толь” хэмээн алдаршсан бас нэгэн гар бичмэл толь бий бөгөөд түүнийг барагцаалбал XV зууны эцэсээр Хасан бин Хусан Имад ал Карахисари /*Hasan bin Husan 'Imād al-Qarāhisārī*/ гэдэг хүн зохиожээ. Угтаа “Шамил үл-луга” (*Šamil ül-luḡa*) нэртэй тэрхүү түрэг-перс толийн хавсаралт болох араб-перс-турк-монгол дөрвөн

¹⁰ Фазлаллах Рашид ад-Дин, Джами'ат-таварих, том 1. Часть 1, Москва, 1965.

¹¹ Рашид-ад-Дин, Судрын чуулган, орч. Ц.Сүрэнхорлоо, УБ., 2002.

¹² П.М.Мелиоранский, Араб филолог о монгольском языке, СПб., 1903.

¹³ Н.Поппе, Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, М.-Л., 1938, стр. 432-451, М. Weiers, Ein arabisch-mongolischer Wörterspiegel aus der Bibliotheca Corsini in Rom, ZS. 6, 1972, 7-29 + 30 Tafeln

¹⁴ Н.Поппе, Монгольские названия животных в труде Хамдуллаха Казвини, ЗКВ т. I . 1925, 195-208, P. Pelliot, Les formes et mongoles dans la nomenclature zoologique du nughatī'ī-kulub, BSOAS 6, 1931, p. 555-580.

хэлний бэсрэгхэн толийн дотор 400 гаруй монгол үгс байгаа”¹⁵ хэмээн академич Д.Төмөртоогоо тэмдэглэжээ. Уг толийн талаар Л.Лигетийн¹⁶ хийсэн судалгаа эдүгээ хүртэл үнэ цэнээ хадгалсаар ажээ.

Мукаддимат ал-Адаб толь

Араб үсгийн монгол дурсгалуудын дотроос хамгийн том нь XII зууны үеийн Хорезмийн нэрт эрдэмтэн Абул-Касим Махмуд бин Омар ал-Замахшири /1075-1144/-ийн зохиосон “Мукаддимат ал-Адаб” хэмээх араб-перс толийн монгол хадмал орчуулга юм.

Н.Поппе уг толийн бүх үгсийг цагаан толгойн дэс дараалалд оруулж, дуудлагын галигаар буулгаж, араб бичлэг, орос орчуулгын хамт нийтлүүлжээ¹⁷.

Академич Д.Төмөртоогоо энэхүү дурсгалыг “Уг хадмал орчуулгыг хожим XIV-XV зууны үед нэмж хийсэн бөгөөд тэр нь үгийн тоо хэмжээ төдийгүй, авиазүй тогтолцоо, хэлзүйн хэлбэрүүд, үгсийн сангийн онцлогоороо хамгийн баялаг дурасхал юм”¹⁸ хэмээн үнэлсэн байдаг.

Мөн Японы эрдэмтэн Ё. Сайто уг толийг судлан хэвлүүлсэн байна¹⁹.

Лайдений толь

Лайдений толь хэмээн нэршсэн дурсгал бол эдүгээ Холландын Лайден хотын номын санд хадгалагдаж байгаа 240 гаруй үгтэй монгол-перс, 400 орчим үгтэй араб-монгол толь юм. Нэрт эрдэмтэн Н.Поппе энэхүү толийн талаар дэлгэрэнгүй судалгаагаа хэвлүүлжээ²⁰.

Японы эрдэмтэн Ё. Сайто уг толийг судлан хэвлүүлсэн байна²¹.

Хааны толь /6 хэлний/

“Расулидын ван нарын нэг *al-Malik al-Afdal al-'Abbas b. 'Ali (1363-1377)* нь онцгой ач холбогдолтой, олон тооны нэр томъёо бүхий The Rasulid Hexaglot (*Расулидын зургаан хэлний толь*) хэмээх олон хэлний толийг бичжээ”²².

Уг толь нь араб, перс, түрэг, герег, армян, монгол гэсэн зургаан хэлний толь бөгөөд 1960-аад оноос эхлэн түүнийг судлах нэгэн томоохон төсөл хэрэгжиж байсан ба

¹⁵ Д.Төмөртоогоо, Араб үсгийн монгол дурасхалын судалгаа /удирдхал, үгийн харьцуулсан толь, номзүй/, УБ., 2002, тал. I.

¹⁶ L.Ligeti, Un vocabulaire mongol d'Istanbul, АОН 14, 1962, 3-99; Notes sur le vocabulaire mongol d'Istanbul, АОН 16, 1963, 107-174.

¹⁷ Н.Поппе, Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, /ТИВ 14/, т. I-II, М-Л., 1938.

¹⁸ Д.Төмөртоогоо, Араб үсгийн монгол дурасхалын судалгаа /удирдхал, үгийн харьцуулсан толь, номзүй/, УБ., 2002, тал. I.

¹⁹ Saito, Yoshio., A Phonetic Study of the Middle Mongolian Language in Arabic Transcriptions, Tokyo Gakugei University, January 1997.

²⁰ N.Poppe, Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift. –Bull. de l'acad. des Sc. de l' URSS, 1927 (1009-1040, 1251-1274), 1928(55-80)

²¹ Saito, Yoshio., The Mongolian Words in Kitâb Majmû' Turjumân Turkî wa-'ajamî wa-Muğalî: Text and Index, SHOVKADOH, Kyôto, 2006.

²² Г.Цэцэгдарь, Peter B. Golden, THE KING'S DICTIONARY The Rasulid Hexaglot, Brill, Leiden-Boston-Köln, 2000, xii + 418 + Ms. p. 186-211, Altaica III, УБ., 2004, т. 154.

уг төслийн багийнхан Л.Лигети, Халасы-Кун, П.Б.Голден, Эдмунд Шүлц зэрэг нэрт эрдэмтэн судлаачид байжээ. Энэхүү судалгааны ажилд Америкийн Эрдэмтдийн Нийгэмлэгийн Зөвлөлөөс нэлээд тэтгэлэг, туслалцаа үзүүлж байсан боловч 1987 онд Л.Лигети зуурдаар, дараа нь 1991 онд Халасы Кун өвчний улмаас нас нөгчсөн тул төсөл зогсоход хүрсэн байна. Гэвч судалгааны төслийн хүрээнд нэлээд хэдэн бүтээл нийтлэгджээ²³.

Манайд энэхүү толийн судалгааны тойм болон араб-перс-түрэг-монгол, араб-монгол хэлний толиудын гэрэл зургийн эх, профессор Л.Лигети, Г.Кара нарын судалгаан дахь бичлэг, дуудлагын галиг зэргийг харьцуулан үзэхийн сацуу уг бичлэгийн дүрсийн болон дуудлагын галигийг шинээр хийж, улмаар тэдгээрийг бусад араб үсгийн монгол дурсгалуудын зохих үгстэй дүйлгэн, үсэгзүй, хэлний онцлогийг тодруулах зорилгоор хийсэн өөрийн судалгааг доктор Г.Цэцэгдарь нийтлүүлсэн байна²⁴.

в. Араб үсэг түрэг хэлээр уламжлагдан ирсэн дурсгал

“Dāftār-i Ġingiz-nāmā” буюу “Чингисийн цадиг дэвтэр” сурвалж

Уг сурвалж Ижил мөрний эхээр нутагладаг, XVI-XVIII зууны үеийн Татаруудын утга зохиолын хэл найруулгаар бичигдсэнээрээ нэн онцлогтой юм.

Хэдийгээр зохиогч нь тодорхой бус ч тухайн үеийн шилдэг боловсролтон, аман үлгэр домог хийгээд эртний сурвалж бичиг, зохиолыг сайтар мэддэг хүн туурвисан нь дээрх бүтээлээс илэрхий байгаа билээ. Өөрөөр хэлбэл, энэхүү домгийн шинжтэй түүхийн зохиолыг бичихдээ түүхийн олон мэдээ сурвалж, ардын аман домог, туульсыг ихээхэн ашигласан байна.

“Dāftār-i Ġingiz-nāmā” нь туульсын шинжтэй бөгөөд тухайн үеийн түрэг угсаатны олон аман аялгуу, бичгийн хэлний онцлогийг тусгасан хэд хэдэн бөлгөөс бүрдэж байна. Бөлөг тус бүрийн өгүүлэмж өөрийн гэсэн онцлогтой бөгөөд хэтрүүлэл, ихэсгэл, хүншүүлэл зэрэг уран дүрслэлийн арга, хэрэглүүрийг ашиглаж бичсэн нь уг сурвалжийг баатарлагийн туульстай төсөөтэй болгожээ.

Эхний бөлгийн үйл явдал эрт үеэс Чингис хааны үе буюу XIII зуун хүртэл үргэлжилж байгаа бол, төгсгөлийн 6-р бөлөг нь XVII зууны үеийн үйл явдлыг өгүүлээд өндөрлөж байна. Энэ мэтчилэн бөлөг тус бүр өөр өөр цаг үеийн үйл явдлыг тусгаж байгаагаараа онцлог юм.

XIX зуун эхэн үеэс уг сурвалжийн талаарх мэдээ түрэг судлалын ертөнцөд хэдийнээ танил болсон бөгөөд XX зууны үед Оросын судлаачид зарим бөлгүүдийг нь орчуулан хэвлүүлсэн ажээ.

1972 онд “Татарские исторические источники XVII-XVIII вв.” хэмээх бүтээлийг Татарын Казаний их сургуулийн түүхийн тэнхимийн проф. М.А.Усманов хэвлүүлсэн байна. Энэхүү бүтээл хэвлэгдэхээс өмнө тус сурвалжийн 40 гаруй гар бичмэл хувилбар олоод байсан аж.

²³ P.B.Golden, The Byzantine Greek Elements in the Rasulid Hexaglot. Archivum Eurasiae Medii Aevi. V (1985 [1987]), 41-166.

²⁴ Г.Цэцэгдарь, Peter B. Golden, THE KING'S DICTIONARY The Rasulid Hexaglot, Brill, Leiden-Boston-Köln, 2000, xiii + 418 + Ms. p. 186-211, Altaica III, УБ., 2004, т. 152-188.

Казаний их сургуулийн археогеографикийн шинжилгээний ангийнхан Татарын Ижил мөрөн хийгээд Уралын нуруу, түүний ойр хавийн нутгаар хийсэн судалгааныхаа үр дүнд эл сурвалжийн бүрэн ба бүрэн бус хувилбаруудыг шинээр нэмж олсон байна.

Абдулкадыр Инан 1934 онд “Destan-i Çengiz Han Kitabı I” хэмээх бүтээлдээ уг сурвалжийн талаар судлан нийтлүүлжээ.

2002 онд Мажарын эрдэмтэн Maria Ivanics, Mirkasym A.Usmanov нар “Studia Uralo-Altaica” цувралын 44 дүгээрт (герман хэлээр) оршил, удиртгалын хамт хэвлүүлсэн байна²⁵.

Бид уг сурвалжийн тухайлсан судалгааг үгчилсэн болон утгачилсан орчуулгын хамт “CORPUS SCRIPTORUM” цувралын тавдугаар ботид хэвлүүлэхээр бэлтгээд байгаа юм²⁶.

“Däftär-i Çingiz-nāmā” нь олон гар хуулбараар тархсан тул анхны эхээсээ нэлээд зөрүүтэй болсон ажээ.

Судлаач Rieu²⁷, A.Rahim²⁸ нар энэхүү сурвалжийг XVII зууны үед бичигдсэн хэмээн таамаглал дэвшүүлсэн нь эдүгээ олон зүйлээр батлагдсаар байна.

Жишээ нь, уг сурвалж XVII зууны хоёрдугаар хагаст Татарт болсон улс төр, шашны олон зүйл үйл явдлыг агуулсан байдаг нь дээрх таамаглал үнэн болохыг давхар нуталж байна.

Харин энэ мэт араб үсгээр, түрэг төрөл хэлээр бичигдсэн Монголын түүхэнд холбогдох өөр дурсгал одоогоор олдоогүй бололтой.

*Монгол нутаг дахь гэрэлт хөшөө,
хад чулуунаа бүхий араб үсгийн дурсгал.*

Монгол нутаг хад, чулуунаа сийлсэн олон зүйл үсэг бичгийн дурсгалаар баялаг билээ. Тухайлбал: руни, согд, уйгур, араб, перс, монгол, дөрвөлжин, тод, нангиад, манж, төвд гэх мэт.

Эдгээрийн дотроос араб, перс үсгийн дурсгалын судалгааны тоймыг товч өгүүлье. Монгол орноос араб бичгийн 3, перс бичгийн 1 дурсгал олдоод байна. Үүнд:

- Рашаан хадны араб /перс/? бичээс
- Араб бичээс бүхий зоос
- Сэрвэнгийн Адагийн араб бичээс
- Хархорины перс бичээс бүхий гэрэлт хөшөө эдгээр болно.

Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэр уулын зүүн урд хормойн хадан цохиог “Рашаан хад” хэмээн нэрлэдэг байна. Рашаан хадны араб бичгийн дурсгалыг нэрт түүхч Х.Пэрлээ гуай анх олж мэдээлсэн бөгөөд тэрбээр “Рашаан хадны Олон бичээст гол хаданд 5 мөр араб(?) бичээс бий. Бичээсийг хар бийрээр хадны их барсгар толионд татлан бичсэн байна. Энэ нь монгол дахь араб бичээсний гурав дахь нь юм.

²⁵ Däftär-i Çingiz-nāmā (Das Buch der Dschingis-Legende) I. Studia Uralo-altaica. Maria Ivanics, Mirkasym A.Usmanov, Szeged, 2002.

²⁶ Б.Аззаяа, “Däftär-i Çingiz-nāmā” сурвалжийн судалгаа, -“CORPUS SCRIPTORUM”, Tom.V, УБ., 2006, хэвлэлтэнд

²⁷ Rieu, Ch.Catalog of the Turkish Manuscripts in the British Museum. London, 1888

²⁸ Rāxim, G-Gāziz, G. Tatar ādābiyatı tarixi. Kazan. 1925

Бэхний өнгө нь дээрх ХҮ зууны монгол, нанхиад бичээсний бэхтэй ижил байна²⁹ хэмээжээ. Гэвч уг бичээсийн тухай үүнээс өөр мэдээ, уншиж судалсан тэмдэглэл байдаггүй бөгөөд араб гээд (?) тавьсан нь судлаач магадгүй үүнийг араб бичиг гэдэгт бүрэн итгэлгүй байсных болов уу.

МУИС-ийн МХСС-ийн багш, судлаач М.Баярсайханы удирдсан Эх бичиг судлалын гуравдугаар ангийн оюутны хээрийн дадлага, судалгааны ажлын хүрээнд цуглуулсан эх хэрэглэгдэхүүн, гэрэл болон гар зургаас³⁰ үзэхүл уг бичээс нь таван мөр, хар бэхээр татлан бичсэн бичээс байна. Бичээсийн өндөр 27см, өргөн 29 см, мөр хоорондын зай 2 см орчим бөгөөд он цагийн уртад нар, салхи мэтийн байгалийн нөлөөгөөр зарим хэсэг нь баларч уншихуйяа нэн бэрх болсон байна. Уг баримтанд тулгуурлан бид бичээсийн галиг, монгол орчуулгыг хийсэн билээ.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг, эртний барилгын үлдэгдэл бүхий Мэлхийт толгойн орчим буюу Хархорум хотын туурь, Эрдэнэзуу хийдийн хэрмээс урагш нэг километр орчим зайтай газар нэгэн оршуулга илэрснийг 1980 онд малтан шинжилжээ³¹. Малтлагаас араб бичээстэй 2 мөнгөн зоос, нангиад бичээстэй 8 хүрэл зоос олдсон бөгөөд үүнийг эрдэмтэд Жанибек хааны үе (1342-1357)-д холбогдож магадгүй хэмээжээ³².

Сэрвэнгийн Адагийн араб бичээс хэмээх дурсгалыг анх 1973 онд Хэл зохиолын хүрээлэнгийн шинжилгээний анги Төв аймгийн Эрдэнэсант сумын Цүүгэлийн адгийн Сэртэнгийн бичээс гэгдэх засмал боржин чулуунаа нэг талдаа 4 мөр араб бичиг нөгөө талдаа эртний араб тоо бичсэн дурсгал олсныг тус шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд явсан проф.Ц.Шагдарсүрэн мөн ондоо “Утга зохиол урлаг”/№44/ сонинд хэвлүүлжээ.

Тэрбээр 1978 онд дурсгалын ар талд байх гурван оронтой эртний араб тоог нягтлан үзэж, “Лалынхны хэрэглэдэг хижра тооллын 728 юм уу, эсвэл 827 он байна гээд одоо бидний хэрэглэж буй аргын тооллоор бол 1327-1328, эсвэл 1423-1424 он болно”³³ гэжээ.

Харин дурсгалын нүүрэн талын дөрвөн мөр араб бичээсийг бид дээрхи мэдээллийн мөрөөр 2001 оны зун үзэж судлан хэв дардас авсан билээ. Дурсгалын орших газрын нэрийн тухайд дээрхи мэдээ баримтанд тэмдэглэснээр “Сэртэнгийн бичээс” гэж байгаа боловч нутгийн ардууд одоо “Сэрвэнгийн Адагийн бичээс” хэмээн нэрлэж байх юм³⁴.

²⁹ Х.Пэрлээ. Дорнод Монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологичийн тэмдэглэлээс). -Шинжлэх ухаан амьдрал. №4. УБ., 1974.

³⁰ МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг, алтай судлалын тэнхимийн хээрийн дадлага, судалгааны ажлын тайлан. 2006.

³¹ Г.Мэнэс, Д.Баяр. Два погребения монгольского времени из Кара-Корума. -Түүхийн судлал. Tom XXIII, fasc. 14, УБ., 1989. тал. 27-30. В.Е.Войтов. Могилиники Кара-Корума. -Археологические, этнографические и антропологические исследования в Монголии. Новосибирск. 1990. стр. 132-149.

³² Г.Мэнэс, Д.Баяр. Два погребения монгольского времени из Кара-Корума. -Түүхийн судлал. Tom XXIII, fasc. 14, УБ., 1989. тал. 30. (Эдгээр зоос ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын санд хадгалагдаж байна)

³³ Ц.Шагдарсүрэн. Шинээр олдсон араб бичээстэй хошоо. ШУАМ. №2. УБ., 1978. тал.65.

³⁴ Ц.Баттулга, Б.Азжаяа. Монгол нутаг дахь араб, перс бичгийн дурсгалууд. -Acta Historica. Tom.V, fasc. 25. УБ., 2004. тал. 160-163.

Ц.Шагдарсүрэн багшид энэ тухай ярихад яах аргагүй нутгийн өвгөн (худал хэлэхээргүй хүн зааж хэлсэн) болохыг өгүүлсэнд тэрхүү газрын нэрийг тодруулахаар дахин нутгийн олонтой уулзахад бас Сэртэн гэнэ, Сэрвэн гэнэ гэж маргалдаж байсан бөгөөд сумын газрын зурагт тэмдэглэснээр Сэрвэнгийн нурууны адагт байгаа ажээ.

Араб бичээст энэ дурсгал 4 мөрөөс бүтэх бөгөөд араб тоогоор холбогдох он цагийг нь тодорхой бичсэн тухай мэдээ сэлтээс хэтрээгүй, тухайлсан судалгаа хийгдээгүй өнөө хүрсэн бололтой.

Иймд бид хөшөөний эх бичээс болон өөрсдийн авсан хэв дардаст тулгуурлан уншиж тайлсан билээ³⁵.

Өвөрхангай аймгийн Хархорин сум, Эрдэнэзуу хийдийн хашаанд перс бичиг бүхий гэрэлт хөшөө буй. Уг дурсгалыг японы эрдэмтэн Н.Уно, Х.Мураока, К.Мацуда нар тайлан уншиж, япон, англи хэлээр орчуулан хэвлүүлсэн байна³⁶.

Уг хөшөөний перс бичигт нүүрэн талд бадамлянхуа цэцэгт суурилласан соёмбо сийлсэн байдаг. Хөшөөний ар талд ланз, төвд, монгол үсгээр маани бичсэн байна. Перс бичээс нь нийтдээ 39 мөрөөс бүтэх бөгөөд эхний хэсэгт Аллахыг магтан дуулж, төгсгөл хэсэгт нь лалын сүм хийд барьж байгуулахад туслалцаа үзүүлсэн хүмүүсийн нэрсийг дурдаад 742 онд босгосноо тэмдэглэжээ. Энэ нь нийтийн он тооллын 1341 он болно.

Монголын түүхэнд холбогдох араб, перс дурсгалын судалгааны тоймыг товч өгүүлэхэд ийм байна.

Abstract

There are many important sources related to language, history and cultures of Mongolians in the Middle Ages of Arabic and Persian sources. But these sources translated into Mongolian didn't enough. Researchers are approaching in translations or press indirectly.

So, it's important to translate these sources related to language, history and cultures of Mongolians. And we are introducing lightly some of them.

³⁵ Ц.Баттулга, Б.Азаяа, Монгол нутаг дахь араб, перс бичгийн дурсгалууд, -Acta Historica, Tom.V, fasc. 25, УБ., 2004, тал. 160-163.

³⁶ N.Uno, H.Muraka & K.Matsuda, Persian Inscription in Memory of the Establishment of a Khānqāh at Qara-qorum, -Studies on the Inner Asian languages XIY, The Society of Central Eurasian Studies, 1999.

НОМЗҮЙ

- Ала-ад-Дин Ата-Мелик Жувейни**, Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. орч. Бадамням М.Д. УБ., 2006.
- Арьяажав.Б**, Нур-ад-Диний бичгийн 1272 оны араб, монгол эхийн судалгаа. -МУИС, МХСС, Түрэг судлалын тэнхмийн гар бичмэлийн фонд. /бүртгэлийн дугаар: Т-2005_2/, бакалаврын дипломын ажил. УБ., 2005.
- Баттулга.Ц, Азаяа.Б**, Монгол нутаг дахь араб, перс бичгийн дурсгалууд. -Acta Historica. Tom.V. fasc. 25. УБ., 2004, тал. 160-163.
- Войтов.В.Е**, Могильники Кара-Корума. -Археологические, этнографические и антропологические исследования в Монголии. Новосибирск. 1990.
- Мелиоранский.П.М.** Араб филолог о монгольском языке, СПб., 1903.
- МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг, алтай судлалын тэнхимийн хээрийн дадлага, судалгааны ажлын тайлан. 2006.
- Мэнэс.Г, Баяр.Д**, Два погребения монгольского времени из Кара-Корума. -Түүхийн судлал. Tom XXIII. fasc. 14, УБ., 1989, тал. 27-30.
- Поппе.Н**, Монгольские названия животных в труде Хамдуллаха Казвини. ЗКВ т.I, 1925, 195-208.
- Поппе.Н**, Монгольский словарь Мукаддимат ал-Адаб. М-Л., 1938, стр. 432-451.
- Пэрлээ.Х**, Дорнод Монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэлээс). -Шинжлэх ухаан амьдрал. №4, УБ., 1974.
- Рашид-ад-Дин**, Судрын чуулган, орч. Ц.Сүрэнхорлоо. УБ., 2002.
- Төмөртогоо.Д**, Араб үсгийн монгол дурасгалын судалгаа /удирдхал, үгийн харьцуулсан толь, номзуй /. УБ., 2002, тал. I.
- Ууганбаяр.М**, Кыршехирийн ноён Жажагийн хөвгүүн Нур-ад-Диний бичгийн тухайд. -МУИС, эрдэм шинжилгээний бичиг, XX боть, XXXдэвтэр, УБ., 2003, т. 244-265.
- Фазлаллах Рашид ад-Дин**, Джами'ат-таварих, том I, Часть I, Москва, 1965.
- Цэцэгдарь.Г, Peter B. Golden**, THE KING'S DICTIONARY The Rasulid Hexaglot. Brill, Leiden-Boston-Köln, 2000, хш + 418 + Ms. p. 186-211, Altaica III, УБ., 2004, т. 152-188.
- Шагдарсүрэн.Ц**, Шинээр олдсон араб бичээстэй хөшөө. ШУАМ, №2, УБ., 1978, тал.65.
- Ahmet Temir**, Kırşehir emiri Saca oğlu nur el-din'in 1272 tarihli Arapça-Moğolca vakfiyesi, Ankara. 1989.
- 'Ala-ad-Din 'Ata-Malik Juvanini**, The History of the Wold-Conqueror, translated from the Persian by John Andrew Boyle, Manchester University Press. Vol. I, II, London, 1958.
- Alaaddin A.M.Cüveynî**, Tarih-i Cihangüşa, çev. Mürsel Öztürk, Ankara, 1988.
- Däftär-i Čingiz-nāmā** (Das Buch der Dschingis-Legende) I. Studia Uralo-altaica, Maria Ivanics, Mirkasym A.Usmanov, Szeged, 2002.
- L.Ligeti**, Monuments préclassiques I. (XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972.
- L.Ligeti**, Un vocabulaire mongol d'Istanboul, AOH 14, 1962, 3-99; Notes sur le vocabulaire mongol d'Istanboul, AOH 16, 1963, 107-174.
- M.Weiers**, Ein arabisch-mongolischer Wörterspiegel aus der Bibliotheca Corsini in Rom, ZS. 6, 1972, 7-29 + 30 Tafeln

- N.Poppe**, Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift. –Bull. de l'acad. des Sc. de l' URSS, 1927 (1009-1040, 1251-1274), 1928(55-80)
- N.Uno, H.Muraka & K.Matsuda**, Persian Inscription in Memory of the Establishment of a Khānqāh at Qara-qorum, -Studies on the Inner Asian languages XIY, The Society of Central Eurasian Studies, 1999.
- P.B.Golden**, The Byzantie Greek Elements in the Rasulid Hexaglot. Archivum Eurasiae Medii Aevi, V (1985 [1987]), 41-166.
- P.Pelliot**, Les formes et mongoles dans la nomenclature zoologique du nughati'l-kulub, BSOAS 6, 1931.
- Räxım, G-Gäziz, G.** Tatar ädäbiyati tarixi, Kazan, 1925.
- Rieu, Ch.** Catalog of the Turkish Manuscripts in the British Museum, London, 1888
- Saito, Yoshio.**, A Phonetic Study of the Middle Mongolian Language in Arabic Transcriptions, Tokyo Gakugei University, January 1997.
- Saito, Yoshio.**, The Mongolian Words in Kitâb Majmû' Turjumân Turkî wa-'ajamî wa-Muğalî: Text and Index, SHOVKADOH, Kyôto, 2006.

68
 69
 70
 71
 72
 73
 74
 75
 76
 77
 78
 79
 80
 81
 82
 83
 84
 85
 86
 87
 88
 89
 90
 91
 92
 93
 94
 95
 96
 97
 98
 99
 100
 101
 102
 103
 104
 105
 106
 107
 108
 109
 110
 111
 112
 113
 114
 115
 116
 117
 118
 119
 120
 121
 122
 123
 124
 125
 126
 127
 128
 129
 130
 131
 132
 133
 134
 135
 136
 137
 138
 139
 140
 141
 142
 143
 144
 145
 146
 147
 148
 149
 150
 151
 152
 153
 154
 155
 156
 157
 158
 159
 160
 161
 162
 163
 164
 165
 166
 167
 168
 169
 170
 171
 172
 173
 174
 175
 176
 177
 178
 179
 180
 181
 182
 183
 184
 185
 186
 187
 188
 189
 190
 191
 192
 193
 194
 195
 196
 197
 198
 199
 200
 201
 202
 203
 204
 205
 206
 207
 208
 209
 210
 211
 212
 213
 214
 215
 216
 217
 218
 219
 220
 221
 222
 223
 224
 225
 226
 227
 228
 229
 230
 231
 232
 233
 234
 235
 236
 237
 238
 239
 240
 241
 242
 243
 244
 245
 246
 247
 248
 249
 250
 251
 252
 253
 254
 255
 256
 257
 258
 259
 260
 261
 262
 263
 264
 265
 266
 267
 268
 269
 270
 271
 272
 273
 274
 275
 276
 277
 278
 279
 280
 281
 282
 283
 284
 285
 286
 287
 288
 289
 290
 291
 292
 293
 294
 295
 296
 297
 298
 299
 300
 301
 302
 303
 304
 305
 306
 307
 308
 309
 310
 311
 312
 313
 314
 315
 316
 317
 318
 319
 320
 321
 322
 323
 324
 325
 326
 327
 328
 329
 330
 331
 332
 333
 334
 335
 336
 337
 338
 339
 340
 341
 342
 343
 344
 345
 346
 347
 348
 349
 350
 351
 352
 353
 354
 355
 356
 357
 358
 359
 360
 361
 362
 363
 364
 365
 366
 367
 368
 369
 370
 371
 372
 373
 374
 375
 376
 377
 378
 379
 380
 381
 382
 383
 384
 385
 386
 387
 388
 389
 390
 391
 392
 393
 394
 395
 396
 397
 398
 399
 400
 401
 402
 403
 404
 405
 406
 407
 408
 409
 410
 411
 412
 413
 414
 415
 416
 417
 418
 419
 420
 421
 422
 423
 424
 425
 426
 427
 428
 429
 430
 431
 432
 433
 434
 435
 436
 437
 438
 439
 440
 441
 442
 443
 444
 445
 446
 447
 448
 449
 450
 451
 452
 453
 454
 455
 456
 457
 458
 459
 460
 461
 462
 463
 464
 465
 466
 467
 468
 469
 470
 471
 472
 473
 474
 475
 476
 477
 478
 479
 480
 481
 482
 483
 484
 485
 486
 487
 488
 489
 490
 491
 492
 493
 494
 495
 496
 497
 498
 499
 500
 501
 502
 503
 504
 505
 506
 507
 508
 509
 510
 511
 512
 513
 514
 515
 516
 517
 518
 519
 520
 521
 522
 523
 524
 525
 526
 527
 528
 529
 530
 531
 532
 533
 534
 535
 536
 537
 538
 539
 540
 541
 542
 543
 544
 545
 546
 547
 548
 549
 550
 551
 552
 553
 554
 555
 556
 557
 558
 559
 560
 561
 562
 563
 564
 565
 566
 567
 568
 569
 570
 571
 572
 573
 574
 575
 576
 577
 578
 579
 580
 581
 582
 583
 584
 585
 586
 587
 588
 589
 590
 591
 592
 593
 594
 595
 596
 597
 598
 599
 600
 601
 602
 603
 604
 605
 606
 607
 608
 609
 610
 611
 612
 613
 614
 615
 616
 617
 618
 619
 620
 621
 622
 623
 624
 625
 626
 627
 628
 629
 630
 631
 632
 633
 634
 635
 636
 637
 638
 639
 640
 641
 642
 643
 644
 645
 646
 647
 648
 649
 650
 651
 652
 653
 654
 655
 656
 657
 658
 659
 660
 661
 662
 663
 664
 665
 666
 667
 668
 669
 670
 671
 672
 673
 674
 675
 676
 677
 678
 679
 680
 681
 682
 683
 684
 685
 686
 687
 688
 689
 690
 691
 692
 693
 694
 695
 696
 697
 698
 699
 700
 701
 702
 703
 704
 705
 706
 707
 708
 709
 710
 711
 712
 713
 714
 715
 716
 717
 718
 719
 720
 721
 722
 723
 724
 725
 726
 727
 728
 729
 730
 731
 732
 733
 734
 735
 736
 737
 738
 739
 740
 741
 742
 743
 744
 745
 746
 747
 748
 749
 750
 751
 752
 753
 754
 755
 756
 757
 758
 759
 760
 761
 762
 763
 764
 765
 766
 767
 768
 769
 770
 771
 772
 773
 774
 775
 776
 777
 778
 779
 780
 781
 782
 783
 784
 785
 786
 787
 788
 789
 790
 791
 792
 793
 794
 795
 796
 797
 798
 799
 800
 801
 802
 803
 804
 805
 806
 807
 808
 809
 810
 811
 812
 813
 814
 815
 816
 817
 818
 819
 820
 821
 822
 823
 824
 825
 826
 827
 828
 829
 830
 831
 832
 833
 834
 835
 836
 837
 838
 839
 840
 841
 842
 843
 844
 845
 846
 847
 848
 849
 850
 851
 852
 853
 854
 855
 856
 857
 858
 859
 860
 861
 862
 863
 864
 865
 866
 867
 868
 869
 870
 871
 872
 873
 874
 875
 876
 877
 878
 879
 880
 881
 882
 883
 884
 885
 886
 887
 888
 889
 890
 891
 892
 893
 894
 895
 896
 897
 898
 899
 900
 901
 902
 903
 904
 905
 906
 907
 908
 909
 910
 911
 912
 913
 914
 915
 916
 917
 918
 919
 920
 921
 922
 923
 924
 925
 926
 927
 928
 929
 930
 931
 932
 933
 934
 935
 936
 937
 938
 939
 940
 941
 942
 943
 944
 945
 946
 947
 948
 949
 950
 951
 952
 953
 954
 955
 956
 957
 958
 959
 960
 961
 962
 963
 964
 965
 966
 967
 968
 969
 970
 971
 972
 973
 974
 975
 976
 977
 978
 979
 980
 981
 982
 983
 984
 985
 986
 987
 988
 989
 990
 991
 992
 993
 994
 995
 996
 997
 998
 999
 1000
 1001
 1002
 1003
 1004
 1005
 1006
 1007
 1008
 1009
 1010
 1011
 1012
 1013
 1014
 1015
 1016
 1017
 1018
 1019
 1020
 1021
 1022
 1023
 1024
 1025
 1026
 1027
 1028
 1029
 1030
 1031
 1032
 1033
 1034
 1035
 1036
 1037
 1038
 1039
 1040
 1041
 1042
 1043
 1044
 1045
 1046
 1047
 1048
 1049
 1050
 1051
 1052
 1053
 1054
 1055
 1056
 1057
 1058
 1059
 1060
 1061
 1062
 1063
 1064
 1065
 1066
 1067
 1068
 1069
 1070
 1071
 1072
 1073
 1074
 1075
 1076
 1077
 1078
 1079
 1080
 1081
 1082
 1083
 1084
 1085
 1086
 1087
 1088
 1089
 1090
 1091
 1092
 1093
 1094
 1095
 1096
 1097
 1098
 1099
 1100
 1101
 1102
 1103
 1104
 1105
 1106
 1107
 1108
 1109
 1110
 1111
 1112
 1113
 1114
 1115
 1116
 1117
 1118
 1119
 1120
 1121
 1122
 1123
 1124
 1125
 1126
 1127
 1128
 1129
 1130
 1131
 1132
 1133
 1134
 1135
 1136
 1137
 1138
 1139
 1140
 1141
 1142
 1143
 1144
 1145
 1146
 1147
 1148
 1149
 1150
 1151
 1152
 1153
 1154
 1155
 1156
 1157
 1158
 1159
 1160
 1161
 1162
 1163
 1164
 1165
 1166
 1167
 1168
 1169
 1170
 1171
 1172
 1173
 1174
 1175
 1176
 1177
 1178
 1179
 1180
 1181
 1182
 1183
 1184
 1185
 1186
 1187
 1188
 1189
 1190
 1191
 1192
 1193
 1194
 1195
 1196
 1197
 1198
 1199
 1200
 1201
 1202
 1203
 1204
 1205
 1206
 1207
 1208
 1209
 1210
 1211
 1212
 1213
 1214
 1215
 1216
 1217
 1218
 1219
 1220
 1221
 1222
 1223
 1224
 1225
 1226
 1227
 1228
 1229
 1230
 1231
 1232
 1233
 1234
 1235
 1236
 1237
 1238
 1239
 1240
 1241
 1242
 1243
 1244
 1245
 1246
 1247
 1248
 1249
 1250
 1251
 1252
 1253
 1254
 1255
 1256
 1257
 1258
 1259
 1260
 1261
 1262
 1263
 1264
 1265
 1266
 1267
 1268
 1269
 1270
 1271
 1272
 1273
 1274
 1275
 1276
 1277
 1278
 1279
 1280
 1281
 1282
 1283
 1284
 1285
 1286
 1287
 1288
 1289
 1290
 1291
 1292
 1293
 1294
 1295
 1296
 1297
 1298
 1299
 1300
 1301
 1302
 1303
 1304
 1305
 1306
 1307
 1308
 1309
 1310
 1311
 1312
 1313
 1314
 1315
 1316
 1317
 1318
 1319
 1320
 1321
 1322
 1323
 1324
 1325
 1326
 1327
 1328
 1329
 1330
 1331
 1332
 1333
 1334
 1335
 1336
 1337
 1338
 1339
 1340
 1341
 1342
 1343
 1344
 1345
 1346
 1347
 1348
 1349
 1350
 1351
 1352
 1353
 1354
 1355
 1356
 1357
 1358
 1359
 1360
 1361
 1362
 1363
 1364
 1365
 1366
 1367
 1368
 1369
 1370
 1371
 1372
 1373
 1374
 1375
 1376
 1377
 1378
 1379
 1380
 1381
 1382
 1383
 1384
 1385
 1386
 1387
 1388
 1389
 1390
 1391
 1392
 1393
 1394
 1395
 1396
 1397
 1398
 1399
 1400
 1401
 1402
 1403
 1404
 1405
 1406
 1407
 1408
 1409
 1410
 1411
 1412
 1413
 1414
 1415
 1416
 1417
 1418
 1419
 1420
 1421
 1422
 1423
 1424
 1425
 1426
 1427
 1428
 1429
 1430
 1431
 1432
 1433
 1434
 1435
 1436
 1437
 1438
 1439
 1440
 1441
 1442
 1443
 1444
 1445
 1446
 1447
 1448
 1449
 1450
 1451
 1452
 1453
 1454
 1455
 1456
 1457
 1458
 1459
 1460
 1461
 1462
 1463
 1464
 1465
 1466
 1467
 1468
 1469
 1470
 1471
 1472
 1473
 1474
 1475
 1476
 1477
 1478
 1479
 1480
 1481
 1482
 1483
 1484
 1485
 1486
 1487
 1488
 1489
 1490
 1491
 1492
 1493
 1494
 1495
 1496
 1497
 1498
 1499
 1500
 1501
 1502
 1503
 1504
 1505
 1506
 1507
 1508
 1509
 1510
 1511
 1512
 1513
 1514
 1515
 1516
 1517
 1518
 1519
 1520
 1521
 1522
 1523
 1524
 1525
 1526
 1527
 1528
 1529
 1530
 1531
 1532
 1533
 1534
 1535
 1536
 1537
 1538
 1539
 1540
 1541
 1542